



ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН  
ХАМГААЛАЛЫН САЙД С.ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.4.22 № 03/19 УАГ-ГАГ

Улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн  
байрны асуудлыг шийдвэрлэх тухай.

ХАХНХС таны багцад хамаарагдах “Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийх явцад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төвийн байр худалдан авах 130,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ орон сууцны зориулалттай 3 өрөө байрыг ХТҮГ-т бус Төрийн бус байгууллагад ашиглуулах зориулалтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдаж авсан байна.

Байр худалдаж авах гэрээг 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр захиалагчийг төлөөлж ХТҮГ-ын Нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Д.Бямбацогт, гүйцэтгэгчийг төлөөлж Мөнхсан ХХК-ийн менежер Н.Халиун нар гарын үсэг зурж ХТҮГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч И.Нарантуяа, Мөнхсан ХХК-ийн захирал Н.Булганбаатар нар баталгаажуулжээ.

ХТҮГ нь ХУД-ийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх орон сууцны зориулалттай 28 дугаар байрны 1 тоот байрыг худалдаж авч, эзэмшүүлж буй “Хромсомын өөрчлөлттэй хүүхдэд туслах сан” ТББ-тай хэрхэн хамтран ажиллах болон байр ашиглуулах гэрээ байгуулаагүй, байрны ордерыг аль талынх нь нэр дээр авах нь тодорхойгүй байна.

Иймд Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.1-ийн 12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх,...” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төвийн байр худалдан авах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ орон сууцны зориулалттай 3 өрөө байрыг ХТҮГ-т бус Төрийн бус байгууллагад ашиглуулах зориулалтаар авахдаа хожим нь хөрөнгийг эзэмших асуудлаас шалтгаалж маргаан гарч болзошгүй гэдгийг анхаарах;

2. ХТҮГ, “Хромсомын өөрчлөлттэй хүүхдэд туслах сан” ТББ-тай хэрхэн хамтран ажиллах болон байр ашиглуулах гэрээг байгуулах, байрны ордерыг төрийн байгууллагын нэр дээр авах асуудлыг шийдвэрлэх

3. Улсын төсвийн хөрөнгөөр худалдаж авсан байрны асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэсэн ажлын үр дүнг Үндэсний аудитын газарт 2013 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор албан ёсоор хариу мэдэгдэхийг ХАХНХЯ-ны ТНБД Б.Отгонжаргал, СХОХ-ийн дарга Мөнхзул, ХТҮГ-ын дарга И.Нарантуяа нараас ШААРДАЖ байна

Албан шаардлага

Бичсэн

Үндэсний аудитын газрын ГАГ-ын  
ахлах аудитор  
Г.Цэдэнбалжир  
Нийцлийн аудитын газрын  
аудитор  
Э.Уянга  
УХА0122

Танилцаж, зөвшөөрсөн

Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалалын  
яамны ТНБДарга

Б.Отгонжаргал

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн  
дарга

Х. Мөнхзул

Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга

И.Нарантуяа